



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/В

Улаанбаатар хот

Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн
үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний
хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний
аюулгүй байдлыг хангах тухай

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/07 тоот тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 08 тоот албан даалгаварыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэл хот болон дүүргийн хэмжээнд хүүхдийн амьсгалын замын өвчлөл нэмэгдэж Хан-уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн ачаалал ихсэж байгаатай холбогдуулан дүүргийн 16 хорооны насанд хүрэгчдийг 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл түр хугацаагаар Эрүүл мэндийн төвийн хэвтэн эмчлүүлэх тасагт хэвтүүлэн эмчлэхийг Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /Т.Гэрэлсүрэн/-д даалгасугай.
2. Тандалт сэргийлэлтийн талаар :
 - 2.1. Яаралтай тусламжийн тасгаар үзүүлж байгаа өвчтөний тоог, ӨЭМТ болон ЭМТөв дээр уртасгасан цагаар ажиллаж байгаа эмч нарын үзлэгийн тоог томуу, томуу төст өвчний долоо хоногийн мэдээнд оруулж мэдээлж байхыг Статистикийн их эмч /З.Туяа/-д үүрэг болгосугай.
 - 2.2. Амьсгалын цочмог халдварын тархалтаас сэргийлж, амбулаторийн үзлэгийн кабинетууд, хүлээн авах яаралтай тусламжийн тасгаар үйлчлүүлж буй иргэд, тасагт хэвтүүлэн эмчлүүлж буй өвчтөн, сахиуруудад амны хаалт тогтмол зүүлгэж, Эмч, эмнэлгийн ажилтан, үйлчлүүлэгч, сахиуруудад гар халдваргүйжүүлэх уусмалыг тогтмол хэрэглүүлж хяналт тавьж ажиллахыг тасаг нэгжийн дарга эрхлэгч нарт үүрэг болгосугай.
3. Тасаг нэгжийн болон Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт даалгах нь:
 - 3.1. Томуу, томуу төст өвчний тархалтын үед баримтлах оношилгоо, эмчилгээний заавар зөвлөмжийг мөрдөж ажиллах
 - 3.2. Тусламж үйлчилгээний урсгал хөдөлгөөнийг зохицуулан хүнд өвчтөнийг харъяалал харгалзахгүй хэвтүүлэн эмчлэх
 - 3.3. Эрчимт эмчилгээний амьсгалын аппаратын үйл ажиллагааг тогтмол шалган хяналт тавих
 - 3.4. Амьсгалын зам саадтай, хүчилтөрөгчийн хэрэгцээтэй өвчтөнийг 2 цаг тутам пульсометрээр хэмжиж, хяналтыг тогтмолжуулах, хүчилтөрөгч эмчилгээг тасралтгүй хийх нөхцөлийг бүрдүүлэх
 - 3.5. ӨЭМТ-ийн тусламж үйлчилгээг гэрийн эргэлтэнд шилжүүлэх

6 170 70 0058

- 3.6. Эмнэлгийн яаралтай тусламжийн тасгаар үзүүлээд буцсан, эмнэлэгт эмчлүүлэн гарсан хүүхдүүдийн мэдээллийг өдөр бүр ӨЭМТ-үүд авч хяналт эргэлтийг сайжруулах
- 3.7. Эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, шаардлагатай эмийн нөөц бүрдүүлэх
- 3.8. Анагаах ухааны чиглэлийн их, дээд сургуулийн төгсөх ангийн оюутнууд, ахмад эмч, сувилагч нарыг нэмэлтээр ажиллуулах
4. Томуу томуу төст өвчнөөс сэргийлэх талаарх сургалт сурталчилгаа мэдээллийг олон нийтэд өргөнөөр сурталчилах ажлыг зохион байгуулахыг сургалтын арга зүйч /Ч.Гүнчинхорлоо/-д үүрэг болгосугай.
5. ЭМС-ын 2019 оны 08 тоот албан даалгаварыг хэрэгжүүлэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг 14 хоног тутам Пүрэв гаригийн 12:00 цагт ХӨСҮТ-ийн Томуугийн тандалтын нэгжид хүргүүлж байхыг Тархвар судлаач /Н.Ганчимэг/-т үүрэг болгосугай.
6. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээнийн чанарын албаны дарга /Н.Оюунмэд/-д даалгасугай.

ДАРГА



Э.БОДЬЦЭЦЭГ